



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: -2025/023/ - -

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Санхүү нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261628 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Аудитор : Б.Эрдэнэзул  
Утас:261740 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: Л.Насанбуян  
Утас:99093142 Цахим хаяг: [Ajumergenaudit.mon@gmail.com](mailto:Ajumergenaudit.mon@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025-03-17 № 07/1068  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## ГЕОЛОГИЙН СУДАЛГАА- ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭНХТӨР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 465.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Татан буугдсан Геологийн судалгааны төв, Геологийн төв лабораториас шилжин ирсэн, нь тодорхойгүй 96 харилцагчтай холбоотой 445.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлж, үр дүнтэй арга хэмжээ аваагүй;
- Геологийн төв лаборатори, Геологийн судалгааны төв 2 байгууллагыг нэгтгэхэд биетээр хүлээж аваагүй 12.6 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “оршин байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 9 төсөл хэрэгжүүлснээс олон улсын хамтарсан "Таван Улс 3D", "Өндөр технологийн түүхий эд, ховор металл, газрын ховор элементийн эрлийн ажил-1", Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын "Овоот толгой-50", "Торлог-Уул-50" гэсэн 4 төслийг амжилттай хэрэгжүүлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/66 дугаар тушаалаар Үндэсний геологийн албаны геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгсөн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орчин үеийн дэвшилтэт техник, технологийн агаарын геофизикийн судалгаагаар дэлхийд тэргүүлэгч Австралийн Икскалибур Авиашн Австралиа компанитай хамтарсан нийт 30,268.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Монгол орны 5 аймгийн 31 сумдын нутгийн 202,476.43 кв.км талбайг хамрах "Агаарын геофизик 2024" төслийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Тайлант онд дээрх төслийн зориулалтаар 15,107.2 сая төгрөгийн санхүүжилт авснаас 14,199.1 сая төгрөгийг зарцуулж, нийт 37,813.2 т.км нислэг үйлдэж, 5.8 террабайт анхдагч датаг Үндэсний геологийн албанд хүлээлгэж өгсөн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ нь нийт 223 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаагаас тайланд онд нийт ажилтнуудын 30 орчим хувийг ажлаас чөлөөлж, томилсон, 10 орчим хувийн ажлын байрыг сэлгэн томилсон байна. Мэргэжилтэй боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахгүй байгаа нь ажлын чанар, бүтээмжид нөлөөлөх эрсдэлтэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5,463,554,958.22	7,847,303,027.30
1.1.2	Дансны авлага	2,164,672,413.55	1,981,137,434.19
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	490,850,008.90	694,531,782.95
1.1.6	Бараа материал	1,492,572,191.52	1,665,695,018.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	39,482,720.98	757,976,212.95
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>9,651,132,293.17</b>	<b>12,946,643,476.26</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,739,696,139.71	9,282,847,663.13
1.2.2	Биет бус хөрөнгө	366,215,244.90	366,215,244.90
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,105,911,384.61</b>	<b>9,649,062,908.03</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,757,043,677.78</b>	<b>22,595,706,384.29</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	4,223,580,224.10	6,899,672,186.09
2.1.1.3	Татварын өр	1,290,168,520.84	489,623,535.44
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	369,977,908.00	821,483,571.22
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,064,731.81	13,225,949.81
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,892,791,384.75</b>	<b>8,224,005,242.56</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	-
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,892,791,384.75</b>	<b>8,224,005,242.56</b>
2.3	<b>Эздийн өмч</b>	-	-
2.3.1	Төрийн өмч	5,749,615,252.73	5,749,615,252.73
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,114,637,040.30	8,622,085,889.00
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>13,864,252,293.03</b>	<b>14,371,701,141.73</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>19,757,043,677.78</b>	<b>22,595,706,384.29</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>15,735,603,494.81</b>	<b>24,047,430,298.56</b>
2	Борлуулалтын өртөг	12,745,476,130.06	20,906,968,490.84
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>2,990,127,364.75</b>	<b>3,140,461,807.72</b>
5	Хүүгийн орлого	15,871,793.25	140,445,514.56
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,550,144,114.79	2,415,871,459.74
12	Бусад зардал	778,393,777.80	91,782,848.36
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(3,289,154.69)	(95,712.16)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	0.00	675,260.44
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>674,172,110.72</b>	<b>773,832,562.46</b>
19	Орлогын татварын зардал	147,883,771.69	100,615,663.76
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>526,288,339.03</b>	<b>673,216,898.70</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>526,288,339.03</b>	<b>673,216,898.70</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	26,271,828.38	0.00
23.3	Бусад олз ( гарз )	26,271,828.38	0.00
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>552,560,167.41</b>	<b>673,216,898.70</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	552,560,167.41	552,560,167.41
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,749,615,252.73</b>	<b>8,114,637,040.30</b>	<b>13,864,252,293.03</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	5,749,615,252.7	8,114,637,040.30	13,864,252,293.03
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	673,216,898.70	673,216,898.70
16	Зарласан ногдол ашиг		(165,768,050.00)	(165,768,050.00)
17	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,749,615,252.73</b>	<b>8,622,085,889.00</b>	<b>14,371,701,141.73</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>12,770,447,028.77</b>	<b>28,032,600,595.36</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	12,038,494,675.35	26,072,159,485.43
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан		10,267,055.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	12,703,952.00	18,243,713.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	719,248,401.42	1,931,930,341.93
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>7,313,976,485.26</b>	<b>24,808,534,990.01</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,347,129,455.00	4,225,245,137.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад	662,874,092.64	1,142,117,078.05
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,760,705,820.73	6,896,417,193.67
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	213,700,328.94	30,829,836.37
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	60,266,387.55	1,085,009,461.01
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,279,654,146.60	3,338,391,579.88
1.2.9	Бусад мөнгөн зарлага	989,646,253.80	8,090,524,703.30
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,456,470,543.51</b>	<b>3,224,065,605.35</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>12,972,504.18</b>	<b>141,161,514.56</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	639,000.00	716,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	12,333,504.18	140,445,514.56
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,300,000.00</b>	<b>816,202,555.42</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	3,300,000.00	454,887,555.42
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд		361,315,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>9,672,504.18</b>	<b>(675,041,040.86)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>2,784,030.70</b>
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		2,784,030.70
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,588,089.47</b>	<b>(168,060,526.11)</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт /Ногдол ашиг/	230,200.00	165,768,050.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	2,357,889.47	(2,292,476.11)
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,588,089.47)</b>	<b>(165,276,495.41)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,463,554,958.22</b>	<b>2,383,748,069.08</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>5,463,554,958.22</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,463,554,958.22</b>	<b>7,847,303,027.30</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлтүүд	2023 оны гүйцэтгэл	2024 ОН		ЗӨРҮҮ	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Лабораторийн Үйлдвэрлэл-Шинжилгээ: Үүнд</b>	<b>7,809,509.4</b>	<b>8,620,000.0</b>	<b>8,174,394.1</b>	<b>(445,605.9)</b>	94.8
	Шинжилгээний ажил	7,521,216.1	8,190,000.0	7,795,446.6	<b>(394,553.4)</b>	95.2
	Өнгөт чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэл	121,054.8	160,000.0	103,580.8	<b>(56,419.2)</b>	64.7
	Стандарт загварын борлуулалт	167,238.5	270,000.0	243,821.2	<b>(26,178.8)</b>	90.3
	Ур чадварын сорил зохион байгуулах ажил		-	31,545.5	<b>31,545.5</b>	
	<b>Геологийн судалгааны ажил</b>	<b>7,856,343.3</b>	<b>29,030,513.2</b>	<b>15,873,036.2</b>	<b>(13,157,477.0)</b>	54.7
	Бусад орлого	111,894.4		140,929.4	<b>141,025.1</b>	
2	<b>Нийт орлого</b>	<b>15,777,747.1</b>	<b>37,650,513.2</b>	<b>24,188,551.1</b>	<b>(13,462,057.9)</b>	64.2
3	<b>Нийт зардал</b>	<b>15,077,303.2</b>	<b>37,306,320.8</b>	<b>23,414,718.5</b>	<b>(13,891,697.9)</b>	62.7
	Үүнээс: Удирдлагын зардал	2,283,169.1	2,020,978.7	1,518,332.0	(502,646.7)	75.1
4	Татварын өмнөх ашиг, алдагдал	700,443.9	344,192.5	773,832.6	429,640.0	224.8
5	Орлогын татварын зардал	147,883.8	34,419.2	100,615.7	66,196.4	292.3
6	<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>552,560.1</b>	<b>309,773.2</b>	<b>673,216.9</b>	363,443.7	217.3
7	<b>Төрийн өмчийн ноогдол ашиг</b>	<b>230.2</b>	<b>276,280.1</b>	<b>165,768.0</b>	(110,512.0)	60.0
8	<b>Төсөвт төлөх татвар, шимтгэл Үүнээс:</b>	<b>3,449,529.9</b>	<b>6,104,206.2</b>	<b>5,035,949.2</b>	(1,068,256.9)	82.5
	НӨАТ	1,323,512.9	3,765,051.3	2,343,606.6	(1,421,444.7)	62.2
	ААНОАТатвар	19,277.3	34,419.2	507,187.5	472,768.3	630.2
	ХХОАТатвар	548,714.4	557,483.1	472,779.9	(84,703.2)	86.1
	АТӨЯХ-ийн албан татвар /3 төрлөөр/	2,852.3	5,000.0	1,995.1	(3,004.9)	39.9
	ҮХХ албан татвар	874.0	90,000.0	220,928.3	130,928.3	245.4
	Бусад татвар, төлбөр	70,738.2	3,000.0	139,913.3	136,913.3	466.4
	Нийгмийн даатгалын шимтгэл	1,483,560.8	1,649,252.5	1,349,538.4	(299,714.1)	81.8
9	Батлагдсан ажилтны тоо	223	223	223	-	100.0
10	Нийт цалингийн сан	5,794,041.3	5,986,461.2	5,768,398.0	(218,063.1)	96.4
11	Нэг ажилтны дундаж цалин	2,165.2	2,237.0	2,155.6	(81.5)	96.4
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох		0.99	0.97	(0.0)	97.9

	зардал	0.96				
13	Нийт хөрөнгө оруулалт	39,302.8	2,647,860.0	1,989,965.1	(657,894.9)	75.1
14	Нийт авлага	2,762,470.8	1,150,000.0	2,675,669.2	1,525,669.2	232.6
15	Нийт өглөг	5,892,791.4	1,100,000.0	8,224,005.2	7,124,005.2	86.6

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 1,375.7 сая төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

#### Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд 9 харилцагчтай холбоотой гүйцэтгэлийн баталгааны 1,249.2 сая төгрөгийг авлагын дансанд буруу бүртгэж, тайлагнасан.	1	1,249,167.9			1	1,249,167.9	1	1,249,167.9				
Тайлант онд найдваргүй авлагын нөөцийг 94.3 сая төгрөгөөр илүү байгуулж тайлант үеийн үр дүнг бууруулж тайлагнасан.	1	94,321.1			1	94,321.1	1	94,321.1				
Тайлант онд худалдан авсан шинжилгээний хариуны статистик үзүүлэлтийг гаргадаг 3 жилийн хугацаатай Пролаб программын лицензийн дараагийн 2 жилд зардлаар хүлээн зөвшөөрөх 32.2 сая төгрөгийн төлбөрийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч үр дүнг буруу тайлагнасан.	1	32,177.8			1	32,177.8	1	32,177.8				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,375,666.8</b>			<b>3</b>	<b>1,375,666.8</b>	<b>3</b>	<b>1,375,666.8</b>				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.2 Аудитаар нийт 465.0 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 4.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 7.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 445.9 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 7.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцоулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Геологийн төв лаборатори нь 2011 онд санхүүгийн програмаа сольж Даймонд програмд шилжүүлэхдээ зарим авлагийн үлдэгдлийг буруу шивсэн, 2010-2016 онуудад шинжилгээний төлөгдсөн төлбөрийн хаалтын бичилтийг буруу хийсэн зэргээс 14 харилцагчтай холбоотой 7.2 сая төгрөгийн авлага найдваргүй авлагаар бүртгэлтэй байна.	1	7,254.1					1	7,254.1				
Орон нутагт албан томилолтоор ажилласан тээврийн хэрэгсэлүүдэд олгосон шатахууны зарцуулалтыг Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан нормын дагуу давтан тооцоолоход тогтоосон нормоос нийт 0.9 сая төгрөгийн шатахуун илүү олгосон.	1	943.2	1	943.2								
Хээрийн судалгааны ажил хийхээр орон нутагт албан томилолтоор ажилласан ажилтнуудын 1.0 сая төгрөгийн зочид буудлын зардал нотлох баримтгүй мөн зочид буудлын төлбөр шилжүүлэхдээ 2.8 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн.	1	3,804.0	1	3,804.0								

Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд Монгол Улсад ирж ажилласан гадаадын мэргэжилтнүүдийг өндөр зэрэглэлийн зочид буудалд байрлуулж, нийт 230.9 сая төгрөг шилжүүлсэн байна.	1						1					
Үндсэн хөрөнгийн дансанд 2010-2013 онд ашиглалтад орсон, 2022 онд 2 байгууллагыг нэгтгэхэд Геологийн төв лабораториос дутагдсан хөрөнгө нэрээр үндсэн хөрөнгийн жагсаалтад орсон 12.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 2.5 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий 16 нэр төрлийн 41 ш хөрөнгө дутагдсан үндсэн хөрөнгө гэсэн нэршлээр бүртгэлтэй байна.	1	2,492.7			1	2,492.7						
Татан буугдсан Геологийн судалгааны төв, Геологийн төв лабораториас шилжин ирсэн, барагдах эсэх нь тодорхойгүй 96 харилцагчтай холбоотой 445.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх үр дүнтэй арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.	1	445,936.9							1	445,936.9		
Тайлант онд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 4.6 сая төгрөг зарцуулсан байна.	1	4,562.0			1	4,562.0						
<b>ДҮН</b>	<b>7</b>	<b>464,992.9</b>	<b>2</b>	<b>4,747.2</b>	<b>2</b>	<b>7,054.7</b>	<b>2</b>	<b>7,254.1</b>	<b>1</b>	<b>445,936.9</b>		

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12,577.8 сая төгрөгийн орлогын 140 гүйлгээ, 2,902.4 сая төгрөгийн зарлагын 115 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1		1			
<b>Дүн</b>	<b>1</b>		<b>1</b>			